



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР

УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
70.8 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА

Аудитын сэдэв: Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн
Аудитын код: ГНАГ-2024/17-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Д.Энхболд

Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Х.Баярмаа

Утас: 261745, Цахим хаяг: bayarmaakh@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батчимэг

Утас: 261639, Цахим хаяг: batchimegb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Сандуйжав

Утас: 329876, Цахим хаяг: sanduijavb@audit.gov.mn

Ахлах аудитор Х.Энх-Амгалан

Утас: 261745, Цахим хаяг: enkhmagalankh@audit.gov.mn

Ахлах аудитор Э.Уужимсан

Утас: 261745, Цахим хаяг: uujiimsane@audit.gov.mn

Аудитор Ш.Наранбаатар

Цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

Аудитор Ж.Чинбат

Цахим хаяг: chinbatj@audit.gov.mn

Аудитор Н.Онон

Цахим хаяг: nonn@audit.gov.mn

Аудитор Д.Доржнамжим

Цахим хаяг: dorjnamjimd@audit.gov.mn

Аудитор С.Оюун-Эрдэнэ

Цахим хаяг: oyunderdenes@audit.gov.mn

Аудитор А.Учрал

Цахим хаяг: uchrala@audit.gov.mn

Аудитор А.Төгөлдөр

Цахим хаяг: tuguldura@audit.gov.mn

Улаанбаатар хот. 2024 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.2, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэл нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-д даалгасугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд (Ч.Хүрэлбаатар), Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (Д.Амарбаясгалан) нарт тус тус зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Д.ЗАГДЖАВ

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	5
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	5
Аудитын зорилго	5
БҮЛЭГ 1. УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУСГАГДААГҮЙ БАЙНА	7
Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан ч зарим ТАХ 2023 оны төсвийн тухай хуульд тусаагүй байна	7
Хуульд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгасан байна	9
Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэд, олон нийтийн санал, оролцоо хангалтгүй байна	11
БҮЛЭГ 2. УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ЯМАР ҮР НӨЛӨӨ, ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТ БИЙ БОЛСНЫГ ТООЦООГҮЙ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ БОДИТОЙ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА	14
Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг санхүүжүүлэх “Төр, хувийн хэвшлийн түншлэл болон бусад” эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүйгээс санхүүжилтийг бүрэн шийдвэрлээгүй байна	14
Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой үнэлээгүй, нийгэм, эдийн засагт үзүүлсэн үр нөлөөг үнэлж тооцоогүй байна	16
ДҮГНЭЛТ	23
ЗӨВЛӨМЖ.....	24
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	25
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР.....	30

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ГНАГ	Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах ажил
ГА	Гүйцэтгэлийн аудит
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
МБ	Монголбанк
АТГ	Авлигатай тэмцэх газар
ШС	Шадар сайд
ҮСХД	Үндэсний статистикийн хорооны дарга
ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
ЗГХЭГД	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
СаС	Сангийн сайд
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалахын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
СаЯ	Сангийн яам
СоЯ	Соёлын яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЦХХХЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
УХЖТ	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын Тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн уялдаа	7
Хүснэгт 2	Санхүүжих дүн зөрүүтэй тусгагдсан ТАХ	7
Хүснэгт 3	ТАХ-ний зураг төсвийн мэдээлэл	9
Хүснэгт 4	ТЕЗ-чид ТАХ-ний “Хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл”-ийг тооцоолсон байдал	10
Хүснэгт 5	ТЕЗ-ийн саналд үндэслэн байдал	13
Хүснэгт 6	ТАХ-ний санхүүжилтийн мэдээлэл	14
Хүснэгт 7	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд туссан санхүүжилтийн дүнгийн харьцуулалт	14
Хүснэгт 8	Санхүүжилтийн гүйцэтгэл	15
Хүснэгт 9	Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан бодлогын үнэлгээ	16
Хүснэгт 10	Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан зорилгын үнэлгээ	16
Хүснэгт 11	Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээ	18
Хүснэгт 12	Бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт	20

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Шалгуур үзүүлэлтээр задарсан ТАХ-ний тоо	7
Дүрслэл 2	ТАХ-ний гүйцэтгэл	15
Дүрслэл 3	ТАХ-ний зорилтот түвшинд хүрээгүй шалтгаан	15
Дүрслэл 4	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт	22

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга
Хавсралт 1	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд зөрүүтэй туссан ТАХ-ний жагсаалт
Хавсралт 2.1	Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нь хасагдаж туссан төсөл, арга хэмжээ
Хавсралт 2.2	Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нь нэмэгдэж туссан төсөл, арга хэмжээ
Хавсралт 3	ТЕЗ-чидаас хүргүүлсэн саналд санхүүжих дүн нь тусгагдсан ч улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд санхүүжих дүнгүй туссан ТАХ-ний жагсаалт
Хавсралт 4	Зураг төсөвгүй ТАХ-ний жагсаалт
Хавсралт 5	Суурь үзүүлэлттэй ТАХ-нд суурь түвшнийг тусгаагүй ТАХ-ний жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/152 дугаар тушаалыг үндэслэн “Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилго

Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хууль, журамд заасан шаардлагад нийцүүлж, тухайн жилийн төсвийн тухай хууль, дүнд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулсан эсэх;
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийг бодитой үнэлэн, үр ашгийг тооцсон эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөг боловсруулсан, хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд болон холбогдох бусад байгууллагыг хамруулан тус төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үнэлгээний баримт материалын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Мөн Үндэсний статистикийн хорооноос хуульд заасан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний баримт материалыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, ярилцлага, судалгаа хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль,
- Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хууль,
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”,
- Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”,
- Засгийн газрын 2021 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”,
- Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”,
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”,
- Холбогдох бусад хууль, эрх зүйн актууд,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- Шилэн дансны тухай хууль,
- Төсөл, арга хэмжээний батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ болон бусад шаардлагууд.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Х.Баярмаа, Б.Батчимэг нар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Сандуйжав, Х.Энх-Амгалан, Э.Уужимсан, аудитор Ш.Наранбаатар, Ж.Чинбат, А.Мөнхбадрал, Н.Онон, Д.Доржнамжим, С.Оюун-Эрдэнэ, А.Учрал, А.Төгөлдөр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУСГАГДААГҮЙ БАЙНА

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан ч зарим ТАХ 2023 оны төсвийн тухай хуульд тусаагүй байна

1.1. Улсын хөгжлийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд нийт 75 төсөл, арга хэмжээг 201 шалгуур үзүүлэлт бүхий төсөл, арга хэмжээнд задалж хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Дүрслэл 1. Шалгуур үзүүлэлтээр задарсан ТАХ-ний тоо



1.2. Эдгээр төсөл, арга хэмжээ нь дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн эсэхэд шинжилгээ хийхэд:

Нийцсэн

Улсын хөгжлийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцүүлэн боловсруулсан байна.

1.3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан 201 төсөл, арга хэмжээнээс “Улсын төсөв болон гадаадын зээл тусламж”-ийн эх үүсвэрээс санхүүжих нийт 156 ТАХ байна. Эдгээр ТАХ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуультай уялдсан байдлыг авч үзвэл:

Хүснэгт 1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн уялдаа

Төсөл арга хэмжээний тоо /шалгуур үзүүлэлт/	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд туссан	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусаагүй
156	123	33

Эх сурвалж: Аудиторын тооцоолол (Зөрүүтэй ТАХ-ний жагсаалтыг **Хавсралт 1**-ээс харна уу)

1.4. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд туссан зарим төсөл, арга хэмжээ нь тус хуульд нэршил болон санхүүжих дүн зөрүүтэй байна.

Санхүүжих дүн зөрүүтэй

Хүснэгт 2: Санхүүжих дүн зөрүүтэй тусгагдсан ТАХ /сая төгрөг/

Үзүүлэлт	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн ¹
Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нь хасагдаж туссан	41	883,811.9
Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нь нэмэгдэж туссан	30	747,614.2

Эх сурвалж: Аудиторын тооцоолол (Дэлгэрэнгүйг **Хавсралт 2**-оос харна уу)

1.5. Энэ үзүүлэлтээс харахад Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд нийт 41 ТАХ-ний санхүүжих дүн 883.8 тэрбум төгрөгөөр хасагдаж, 30 ТАХ-ний санхүүжих дүн 747.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж туссан байна.

ТАХ-ний нэршил зөрүүтэй

- ЗТХЯ: “Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн 90.1 км хатуу хучилттай авто зам” ТАХ төсвийн тухай хуульд “Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км хатуу хучилттай авто зам” гэж туссан,
- ЗТХЯ: “Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн 121 км хатуу хучилттай авто зам” ТАХ төсвийн тухай хуульд “Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто зам, 68.3 км” гэж туссан,

Дээрх байдал нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т “Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэсэн заалт бүрэн хэрэгжээгүйг харуулж байна.

1.6. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан ТАХ тухайн жилийн төсвийн тухай хуульд тусаагүй болон зөрүүтэй тусгагдаж байгаад дараах зүйлс нөлөөлж байна.

Хуулийн ялгаатай шаардлага	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан ТАХ-ний шаардлага	• Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, • Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, • Эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэлийг тусгана.
	Төсвийн тухай хуульд заасан ТАХ-ний шаардлага	• Үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан, • Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон, • Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх, • Урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх, • Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.
Шалгуур үзүүлэлтийг бодитой тодорхойлоогүй	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд зарим ТАХ-ний шалгуур үзүүлэлтийг дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан нэршлээр тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл нэгээс дээш жил үргэлжлэх ТАХ-ний нийт ажлын тоо хэмжээгээр шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон.	

¹ Төсвийн зохицуулалт хийсэн дүн

1.7. Төсвийн тухай хуульд тухайн жил хэрэгжүүлэх ТАХ-нд тавих шаардлага Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд тусгасан шаардлагаас өндөр байна. Иймд ТАХ-нд тавих хуулийн шаардлагуудыг харилцан уялдаатай болгох нь зүйтэй байна.

1.8. Эдгээр нөхцөл байдал нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан ТАХ зорилтот түвшинд хүрэхгүй, тус төлөвлөгөөг хэрэгжүүлснээр бий болох үр нөлөөг бууруулах нөхцөлийг үүсгэж байна.

Хуульд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгасан байна

1.9. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2-т улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байхаар тусгасан байна. Үүнд:

Төсөл, арга хэмжээ	Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон.
	Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан.
	Хариуцах эзэнтэй, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх

1.10. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан ТАХ-ний хариуцах эзэн, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон байна. Мөн ТАХ-г эрэмбэлж төлөвлөгөөнд тусгасан байна.

Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээний урьдчилсан тооцоолол	Улсын хөгжлийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан 201 ТАХ-ний 77 нь шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилсан тооцоогүй байна.
---	---

1.11. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд ТАХ-ний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон ч нийт 77 ТАХ-ний шаардлагатай санхүүжилтийн хэмжээг тусгаагүй, хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоогүй байна.

1.12. ТАХ-нд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоогүй нь хэрэгжүүлэгч байгууллагууд хөрөнгө оруулалтын шинж чанаргүй ТАХ-г үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлнэ гэж төлөвлөсөнтэй холбоотой байна.

1.13. Хөрөнгө оруулалтын шинж чанартай зарим ТАХ-ний тухайд холбогдох ТЕЗ-чидаас шаардлагатай санхүүжилтийн хэмжээг тооцон саналаа хүргүүлсэн ч улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд санхүүжилтийн хэмжээг тусгаагүй баталсан байна. (**Хавсралт 3**-аас харна уу)

ТЭЗҮ, зураг төсөв	Улсын хөгжлийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан ТАХ ТЭЗҮ-тэй байх шаардлагыг хангахгүй байна.
--------------------------	---

1.14. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан 201 ТАХ-ээс зураг төсөв шаардлагагүй 95, шаардлагатай 106 ТАХ байна. Зураг төсөв шаардлагатай ТАХ-ний мэдээллийг харуулбал:


Хүснэгт 3. ТАХ-ний зураг төсвийн мэдээлэл

Нийт ТАХ-ний тоо	Үүнээс	
	Зураг төсөвтэй	Зураг төсөвгүй
106	94	12

Дэлгэрэнгүйг **Хавсралт 4**-өөс харна уу.

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.15. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад дараах шаардлагыг хангасан байхаар тусгасан байна. Үүнд:



1.16. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд зорилго, зорилт, ТАХ-ний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтод түвшнийг тусгасан ч дараах алдаа байна. Дурдвал:

Суурь түвшин	• Суурь үзүүлэлттэй ТАХ-нд суурь түвшнийг тусгаагүй, (Дэлгэрэнгүйг Хавсралт 5-аас харна уу) • Шалгуур үзүүлэлттэй уялдаагүй суурь түвшнийг тодорхойлсон.
Шалгуур үзүүлэлт	• Өмнөх онд хэрэгжүүлсэн ТАХ-г шинээр хэрэгжүүлэх байдлаар тусгасан, • Нэгээс дээш жил хэрэгжих ТАХ-ний шалгуурыг тухайн жилд хэрэгжүүлэх ажлын тоо хэмжээгээр бус нийт ажлын тоо хэмжээгээр тогтоосон.

1.17. ТАХ-ний суурь түвшин болон шалгуур үзүүлэлтийг алдаатай, харилцан уялдаагүй тусгасан нь тухайн ТАХ-ний гүйцэтгэлийг бодитой үнэлэхэд хүндрэл учруулж байна.

1.18. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд “Хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл”-ийг тусгаагүй байна.

1.19. Зарим ТЕЗ-чид өөрийн хариуцан хэрэгжүүлэх зарим ТАХ-ний эдгээр шаардлагуудыг тодорхойлсон байсан байна. ТЕЗ-аар ангилан харуулбал:

Хүснэгт 4. ТЕЗ-чид ТАХ-ний “Хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл”-ийг тооцоолсон байдал /ТАХ-ний тоо/

ТЕЗ	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх арга зам, үе шатыг тодорхойлсон эсэх		Төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг тодорхойлсон эсэх		Эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэлийг тусгасан эсэх	
	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тусгасан	Тусгаагүй
АТГ	1	-	1	-	1	-
БОАЖЯ	-	14	-	14	-	14
БОАЖЯ, УУХҮЯ	1	-	1	-	1	-
БТСУХ	-	1	-	1	-	1
БХБЯ	14	-	14	-	14	-
БХЯ	2	-	2	-	2	-

Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн

БШУЯ	-	22	-	22	-	22
ГХЯ	-	2	-	2	-	2
ЗТХЯ	-	24	-	24	13	11
МБ	1	-	1	-	1	-
МБ, СЗХ	2	-	2	-	2	-
НЗДТГ	9	-	9	-	9	-
СаЯ	6	1	6	1	4	3
СаЯ, ХНХЯ, ТАЗ	1	-	1	-	1	-
СоЯ	5	3	7	1	7	1
УУХҮЯ	19	-	19	-	19	-
ХЗДХЯ	-	11	-	11	-	11
ХЗДХЯ, ГХЯ	-	1	-	1	-	1
ХНХЯ	8	-	5	3	6	2
ХХААХҮЯ	7	5	12	-	12	-
ЦХХХЯ	-	1	-	1	-	1
ШС	-	1	1	-	1	-
ЭЗХЯ	4	-	4	-	4	-
ЭМЯ	6	12	6	12	6	12
ЭХЯ	-	17	-	17	-	17
Нийт	86	115	91	110	103	98

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.20. Эдгээр шаардлагуудыг улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгахгүй байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.11-т **“төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлснээр бий болох үр дүнг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхой зохион байгуулалт, дэс дарааллын дагуу төлөвлөхийг**” гэсэн зарчмыг хангахгүй байна.

1.21. ТАХ-ний “Хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө”-г Улсын хөгжлийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэд, олон нийтийн санал, оролцоо хангалтгүй байна

1.22. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд төрийн захиргааны төв болон харьяа, нутгийн захиргааны нийт 61 байгууллагаас 124.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 1771 санал ирүүлсэн байна.

1.23. ТЕЗ-чид улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд өгсөн саналд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс санал авч нэгтгээгүй бөгөөд дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан ТАХ-нд иргэн, аж ахуйн нэгжээс санал авсан. Уг баримт бичигт туссан ТАХ-г улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгадаг тул дахин санал авах шаардлагагүй гэж үзсэн,
- Салбарын баримталж буй бодлогод нийцээгүй, хэрэгжүүлэх боломжгүй хэт жижиг арга хэмжээний санал ирүүлдэг.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1² дэх заалттай нийцэхгүй байна.

1.24. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд дараах байгууллага, зөвлөл санал, дүгнэлт өгөхөөр холбогдох хуулиудад³ заасан байна. Үүнийг авч үзвэл:

Үндэсний статистикийн хороо	•Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай арга зүй, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах, бүх үе шатанд шаардагдах статистик мэдээллийг тухай бүр боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх чиг үүрэгтэй ч энэ чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
Монгол банк	•Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах, холбогдох санал өгөх чиг үүрэгтэй ч энэ чиг үүргээ хэрэгжүүлээгүй, зөвхөн өөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хүргүүлсэн байна.
Ерөнхий сайдын дэргэдэх орон тооны бус төсөв, санхүү, эдийн засгийн үндэсний зөвлөл	• Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ Засгийн газарт хүргүүлэх чиг үүрэгтэй бөгөөд 2022 онд уг зөвлөл байгуулагдаагүй байсан байна.
Төсвийн тогтвортой байдлын зөвлөл	•Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэгтэй бөгөөд 2022 онд уг зөвлөл байгуулагдаагүй байсан байна.

1.25. ЭЗХЯ ТЕЗ-даас ирүүлсэн саналд үндэслэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна. Уг төсөлд “Хүний эрх хөгжил төв”, “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо”, “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Нээлттэй боловсролын төв”-өөс санал ирүүлсэн байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний эцэслэсэн төслийг ЭЗХЯ цахим хуудастаа байршуулсан ч олон нийтээс санал ирээгүй байна. Энэ нь нэг талаар тус яам 2022 онд шинээр байгуулагдсантай холбогдуулан олон нийт мэдээлэл дутмаг байгаатай холбоотой ч нөгөө талаар тус яам иргэн, олон нийтийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйг харуулж байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд олон талын оролцоог хангах, олон нийтээр хэлэлцүүлэх үйл явц хангалтгүй байна.

² Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

³ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7, 9.9, Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1

1.26. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд ТЕЗ-даас хүргүүлсэн санал хэрхэн туссаныг харуулбал:

Хүснэгт 5. ТЕЗ-ийн саналд үндэслэсэн байдал

ТЕЗ	Саналд үндэслэсэн	Саналд үндэслээгүй	Нийт
АТГ		1	1
БОАЖЯ	14		14
БОАЖЯ, УУХҮЯ	1		1
БТСУХ		1	1
БХБЯ	13	1	14
БХЯ	2		2
БШУЯ	14	8	22
ГХЯ	2		2
ЗТХЯ	21	3	24
МБ	1		1
МБ, СЗХ	2		2
НЗДТГ	9		9
СаЯ	5	2	7
СаЯ, ХНХЯ, ТАЗ		1	1
СоЯ	8		8
УУХҮЯ	19		19
ХЗДХЯ	10	1	11
ХЗДХЯ, ГХЯ	1		1
ХНХЯ	8		8
ХХААХҮЯ	9	3	12
ЦХХХЯ		1	1
ШС	1		1
ЭЗХЯ	4		4
ЭМЯ	17	1	18
ЭХЯ	15	2	17
Нийт	176	25	201

Нийт 201 шалгуур үзүүлэлт бүхий ТАХ-ний 176 нь ТЕЗ-даас хүргүүлсэн санал байна.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл батлагдах явцад хэрхэн өөрчлөгдөж байгааг тодруулахад:

- ЭЗХЯ-аас Засгийн газарт хүргүүлсэн 72 арга хэмжээ, 179 шалгуур үзүүлэлт бүхий төслөөс 7 арга хэмжээ, 12 шалгуур үзүүлэлт хасагдаж, 3 арга хэмжээ, 11 шалгуур үзүүлэлт нэмэгдэж батлагдсан байна.

Дээрх байдлаас харахад Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл шат шатанд өөрчлөгдөж байна.

Эх сурвалж: ТЕЗ-дын ЭЗХЯ-нд хүргүүлсэн санал

1.27. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан ТАХ дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт үндэслэсэн, зарим ТАХ хэрэгжүүлэгч байгууллагын “шаардлагатай” гэж хүргүүлсэн санал тусгагдаагүй, иргэд, олон нийтийн санал хангалтгүй байгаа нь төлөвлөлтийн “дээрээс доош” чиглэсэн төлөвлөлттэйг харуулж байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.12-т “Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах” гэсэн зарчмыг хангахгүй байна.

БҮЛЭГ 2. УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ЯМАР ҮР НӨЛӨӨ, ЭЭРЭГ ӨӨРЧЛӨЛТ БИЙ БОЛСНЫГ ТООЦООГУЙ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ БОДИТОЙ ҮНЭЛЭЭГҮЙ БАЙНА

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг санхүүжүүлэх “Төр, хувийн хэвшлийн түншлэл болон бусад” эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүйгээс санхүүжилтийг бүрэн шийдвэрлээгүй байна

2.1. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан ТАХ-ний санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжүүлэх дүнг дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт 6. ТАХ-ний санхүүжилтийн төлөвлөлт /тэрбум төгрөг/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	ТАХ-ний тоо	Санхүүжилтийн дүн
1	Улсын төсөв	129	1,887.7
2	Гадаадын зээл тусламж	26	1,646.5
3	Гадаадын хөрөнгө оруулалт	4	3,004.8
4	Төр хувийн хэвшлийн түншлэл	22	4,197.2
5	Орон нутгийн төсөв	4	420.0
6	Дотоодын хөрөнгө оруулалт	10	1,786.0
7	Хөгжлийн банк	2	51.5
8	Гадаад дотоодын хөрөнгө оруулалт	5	1,243.4
9	Бусад	1	900.0
	Нийт	203	15,137.0

Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөг **15.1** их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Эх сурвалж: Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө

2.2. Эдгээр санхүүжилтийн эх үүсвэрээс улсын төсөв, төр хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл тусламжийн дүнг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуультай харьцуулан харуулбал:

Хүснэгт 7. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд туссан санхүүжилтийн дүнгийн харьцуулалт /тэрбум төгрөг/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	УХЖТ-нд туссан санхүүжилтийн дүн	2023 оны төсвийн тухай хуульд туссан дүн	2023 оны төсвийн тухай хуульд туссан ТАХ-ний тухайн жилд санхүүжих дүн	
				Баталсан	Гүйцэтгэл
1	Улсын төсөв	1,887.7	1,697.2	2,686.0	2,605.8
2	Гадаадын зээл тусламж	1,646.5	1,287.5	1,287.5	1,103.2
3	Төр, хувийн хэвшлийн түншлэл	4,197.2		279.6	251.6
	Нийт	7,731.4	2,984.7⁴	4,253.1	3,960.6

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө, Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэл

2.3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд улсын төсвөөр санхүүжих ТАХ-ний санхүүжилтийн дүн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд хасагдаж туссан байна. Энэ нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан ТАХ зорилтод түвшинд хүрэхгүй байх нэг хүчин зүйл болж байна.

2.4. Нөгөө талаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар баталсан ТАХ-ний тухайн жилийн санхүүжих дүнгээс харахад Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан

⁴ Төсвийн зохицуулалт хийсэн дүн

улсын төсвийн эх үүсвэртэй ТАХ-г бүрэн санхүүжүүлэх боломжтой байна. Иймд эдгээр баримт бичгийг уялдуулах шаардлагатай байна.

2.5. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан ТАХ-ний гүйцэтгэл дараах байдалтай байна.

Дүрслэл 2. ТАХ-ний гүйцэтгэл



Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.6. Дээрх үзүүлэлтээс харахад нийт ТАХ-ний 71.6 хувь нь зорилтот түвшинд хүрээгүй байна. Зорилтот түвшинд хүрээгүй шалтгааныг ангилан харуулбал:

Дүрслэл 3. ТАХ-ний зорилтот түвшинд хүрээгүй шалтгаан



Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.7. Хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын зохион байгуулалт, хамтын ажиллагаа дутагдалтай, санхүүжилт шийдвэрлэгдээгүй зэрэг шалтгаан нь ТАХ зорилтот түвшинд хүрч хэрэгжихгүй байхад голлон нөлөөлсөн байна.

2.8. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд зарцуулсан санхүүжилтийн гүйцэтгэлийг харуулав.

Хүснэгт 8. Санхүүжилтийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Баталсан санхүүжилтийн дүн	Санхүүжилтийн гүйцэтгэл
1	Улсын төсөв	1,887.7	2,427.4
2	Гадаадын зээл тусламж	1,646.5	1,050.0

Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд нийт **9.8** их наяд төгрөг

3	Гадаадын хөрөнгө оруулалт	3,004.8	2,730.4
4	Төр хувийн хэвшлийн түншлэл	4,197.2	-
5	Орон нутгийн төсөв	420.0	129.8
6	Дотоодын хөрөнгө оруулалт	1,786.0	1,973.2
7	Хөгжлийн банк	51.5	83.5
8	Гадаад дотоодын хөрөнгө оруулалт	1,243.4	1,443.8
9	Бусад	900.0	0.9
Нийт		15,137.0	9,839.0

зарцуулсан байна. Энэ нь төлөвлөсөн санхүүжилтийн **64.9** хувийг эзэлж байна.

Эх сурвалж: ЭЗХЯ, ЗГХЭГ-аас ирүүлсэн гүйцэтгэл

2.9. Санхүүжилтийн гүйцэтгэлээс харахад: “**Төр, хувийн хэвшлийн түншлэл** болон **бусад**” гэсэн эх үүсвэрийн санхүүжилт шийдвэрлэхэд хүндрэлтэй, “**Гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж, орон нутгийн төсөв**” гэсэн эх үүсвэрээс санхүүжилтийг бүрэн шийдвэрлэж чадаагүй байна.

2.10. Эдгээр эх үүсвэрийн дутууг Улсын төсөв болон дотоодын хөрөнгө оруулалтаас тодорхой хэмжээнд нөхсөн байна. Энэ нь санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүйг (бэлтгэл ажлыг хангаагүй) илтгэж байна.

Дээрх нөхцөл байдлыг зарим хэрэгжүүлэгч байгууллага “Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан ТАХ гэсэн үндэслэлээр гадаадын зээл тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилтийг татах нөхцөл бүрддэг” гэж тайлбарласан.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой үнэлээгүй, нийгэм, эдийн засагт үзүүлсэн үр нөлөөг үнэлж тооцоогүй байна

2.11. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан бодлого, зорилго, ТАХ-ний гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээг холбогдох байгууллагаар харьцуулан харуулбал:

Тодорхойлсон бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний дундаж үнэлгээ:

Хүснэгт 9. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/

№	Тодорхойлсон бодлого	ТАХ-ний тоо	ТЕЗ-дын үнэлгээ	ЭЗХЯ-ны үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ	Аудитаар үнэлсэн үнэлгээ
1	Хүний хөгжлийн бодлого	23	77.3	76.2	76.2	66.5
2	Эдийн засгийн бодлого	24	76.8	76.1	76.1	66.8
3	Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого	11	95.7	92	92	91.4
4	Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого	8	83.6	79.1	79.1	70.9
5	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	9	87.2	82	82	74.1
Нийт /дундаж/		75	81.2	79.2	79.2	70.8

Эх сурвалж: Үнэлгээ өгсөн байгууллагуудын үнэлгээ

Тодорхойлсон зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний дундаж үнэлгээ:

Хүснэгт 10. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд туссан зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/

Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн

№	Зорилго	ТАХ- ний тоо	ТЕЗ- дын үнэлгээ	ЭЗХЯ- ны үнэлгээ	ЗГХЭГ- ын үнэлгээ	Аудитаар үнэлсэн үнэлгээ
Хүний хөгжлийн бодлого		23	81.7	76.2	76.2	66.5
1	Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ	8	98.8	88.7	88.7	91.8
2	Судалгаа хөгжүүлэлт, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлнэ	2	96.7	96.7	96.7	60
3	Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	4	44.1	43.9	43.9	36.1
4	Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ	3	63.3	53.3	53.3	40
5	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ	5	95	92	92	87
6	Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ	1	92.5	82	82	75.8
Эдийн засгийн бодлого		24	79.5	76.1	76.1	66.8
7	Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, өрийн менежментийг сайжруулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангана	4	100	100	100	100
8	Боомтын сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэн эдийн засгийн өсөлтийг тэтгэж, экспортыг нэмэгдүүлнэ	2	76.2	71.5	71.5	56.5
9	Эрчим хүчний сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд эрчим хүчний найдвартай, тогтвортой эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг шинээр барьж байгуулна	4	72.9	69.8	69.8	66.4
10	Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ	5	72.5	64.5	64.5	57.2
11	Хөдөө аж ахуйн гол нэрийн 19 бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар төлөвлөгөө боловсруулж	5	77.3	73.8	73.8	73

Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн

	хэрэгжүүлнэ. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ					
12	Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ	4	78.6	76.8	76.8	72.5
Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого		11	93.4	92	92	91.4
13	Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн тогтолцоог хөгжүүлнэ	5	97.7	97.7	97.7	96.9
14	Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана	4	88.3	88.3	88.3	80
15	Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан, мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ	2	90	90	90	90
Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого		8	83.6	79.1	79.1	70.9
16	Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ	8	83.6	79.1	79.1	70.9
Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого		9	87.5	82	82	74.1
17	Хот, хөдөөгийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, амьдрах таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ	6	93.5	88.2	88.2	82.4
18	Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ	3	81.6	75.8	75.8	66.6
Нийт /дундаж/		75	81.2	79.2	79.2	70.8

Эх сурвалж: Үнэлгээ өгсөн байгууллагуудын үнэлгээ

2.12. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагууд буюу ТЕЗ-дын хариуцсан ТАХ-ний үнэлгээг харьцуулан харуулав.

Хүснэгт 11. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээ /хувь/

№	Хэрэгжүүлэгч байгууллага	ТАХ-ний тоо	ТЕЗ-дын үнэлгээ	ЭЗХЯ-ны үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ	Аудитаар үнэлсэн үнэлгээ
1	БОАЖЯ	9	78.7	70.3	70.3	68
2	БХБЯ	7	89.2	82.9	82.9	80.9
3	БХЯ	2	90	90	90	90
4	БШУЯ	12	97.3	85.3	85.3	85.9
5	ГХЯ	2	93.3	95	95	93.3
6	ЗТХЯ	4	72.5	60.5	60.5	54.6

7	СаЯ	5	100	95	95	90
8	СоЯ	2	94.3	84.8	84.8	85.1
9	УУХҮЯ	5	72.5	73.5	73.5	58.7
10	ХНХЯ	6	85	79.4	79.4	78.7
11	ХЗДХЯ	6	95	90	90	89.2
12	ХХААХҮЯ	6	79	77.7	77.7	75.2
13	ЦХХХЯ	1	90	90	90	90
14	ШС	1	100	70	70	90
15	ЭЗХЯ	4	97.5	97.5	97.5	82.5
16	ЭМЯ	4	44.1	43.5	43.5	36.1
17	ЭХЯ	4	71.3	68.3	68.3	65.1
18	БТСУХ	1	90	70	70	50
19	МБ	2	100	96.7	96.7	100
20	СЗХ	1	100	100	100	100
21	АТГ	1	100	100	100	100
22	НЗДТГ	4	97.7	87.5	87.5	82.2

Эх сурвалж: Үнэлгээ өгсөн байгууллагуудын үнэлгээ

2.13. Дээрх үнэлгээний дүнгүүдээс харахад холбогдох байгууллагууд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т тусгасан арга зүйн дагуу бодитой үнэлээгүй байна.

Нийт 201 ТАХ-ний үнэлгээний хувьд:

ЭЗХЯ-ны үнэлсэн үнэлгээнээс 7 ТАХ-ний үнэлгээг ЗГХЭГ бууруулж үнэлсэн ч энэ 2 байгууллагын нэгтгэсэн үнэлгээний дүнгүүд бүгд ижил байна.

ЭЗХЯ, ЗГХЭГ нь зарим ТЕЗ-ийн дундаж үнэлгээг алдаатай гаргасан байна. Тухайлбал:

- **ШС-ын хэрэгжүүлсэн арга хэмжээг “100” гэж үнэлсэн ч яам, байгууллагын үнэлгээний нэгтгэлд “70” гэж тусгасан,**
- **МБ-ны хэрэгжүүлсэн арга хэмжээг “100” гэж үнэлсэн ч яам, байгууллагын үнэлгээний нэгтгэлд “96.7” гэж тусгасан,**
- **ЗТХЯ-ны хэрэгжүүлсэн арга хэмжээнд өгсөн үнэлгээний дундаж “70.8” гарсныг яам, байгууллагын үнэлгээний нэгтгэлд “60.5” гэж тусгасан.**

Аудитын үр дүнд нийт 77 ТАХ-ний үнэлгээ ЭЗХЯ-ны үнэлгээнээс өөрчлөгдсөн⁵ буюу тус яам эдгээр ТАХ-ний үнэлгээг бодитой үнэлээгүй байна.

ТЕЗ-дын үнэлгээний тухайд:

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагууд “Өөрсдөөс шалтгаалах ажлаа гүйцэтгэсэн, тухайн ТАХ-тэй ойролцоо арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан” гэх үндэслэлээр үнэлгээгээ нэмэгдүүлэх асуудал түгээмэл байна.

ЭЗХЯ болон ЗГХЭГ-ын үнэлгээний тухайд:

ЭЗХЯ болон ЗГХЭГ нь цаг хугацаа, хүний нөөцийн хүчин зүйлээс хамаарч ТЕЗ-дын албан бичгээр ирүүлсэн тайлан, “Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д байршуулсан мэдээлэлд үндэслэж, шаардлагатай тохиолдолд хариуцсан албан хаагчаас утсаар тодруулга авч ТАХ-ний үнэлгээг гаргаж байна. Энэ нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой бус болгож байна.

⁵ 67 ТАХ-ний үнэлгээ буурч 10 ТАХ-ний үнэлгээ өссөн байна.

2.14. ТАХ-ний хэрэгжилт аудитын багийн үнэлгээгээр буурч байгаа нь зарим ТАХ-ний шалгуур үзүүлэлтийг бодитой тодорхойлоогүйтэй холбоотой байна. Тухайлбал:

- ЭМЯ: “Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж, нэгдсэн сан бүхий мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх” ТАХ-ний шалгуур үзүүлэлтийг “Телемедицин нэвтрэх эрүүл мэндийн байгууллагын тоо” гэж тодорхойлсон байна. Гэтэл Телемедицинийг 2023 оноос өмнө нэвтрүүлсэн бөгөөд тайлант онд шинээр эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлээгүй,
- ЗТХЯ: “Бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих авто зам барих төслүүдийг хэрэгжүүлэх” ТАХ-ний хүрээнд “Чингис-Норовлин-Дадал чиглэлийн 255 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар” гэсэн шалгуур үзүүлэлт тодорхойлсон байна. Энэ ТАХ-ний хүрээнд “Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км хатуу хучилттай авто зам”-ын ажлыг гүйцэтгэж байна,
- ЗТХЯ: Бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих авто зам барих төслүүдийг хэрэгжүүлэх” ТАХ-ний хүрээнд “Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км авто замын барилгын ажлын явц, хувиар” гэсэн шалгуур үзүүлэлт тодорхойлсон байна. Энэ ТАХ-ний хүрээнд “Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 31.08 км” ТАХ-г гүйцэтгэж байна.

2.15. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлийг үр дүнгийн үзүүлэлтээр ангилан харуулав.

Хүснэгт 12: Бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт

Бодлогын нэр	ТАХ-ний тоо	Шалгуур үзүүлэлтээр задарсан ТАХ-ний тоо	Үр дүнгийн үзүүлэлт				Аудитын үнэлгээ (хувиар)
			Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (99-70)	Эрчимжүүлэх шаардлагатай (69-30)	Үр дүнгүй (29-0)	
Хүний хөгжлийн бодлого	23	54	19	15	10	10	66.5
Эдийн засгийн бодлого	24	79	17	31	27	4	66.8
Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого	11	21	9	12	-	-	91.4
Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого	8	11	4	3	3	1	70.9
Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	9	36	8	17	9	2	74.1
Нийт	75	201	57	78	49	17	70.8
Шалгуур үзүүлэлтэд эзлэх хувь			28.4%	38.8%	24.4%	8.5%	-

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.16. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан ТАХ-ээс 57 нь “Үр дүнтэй”, 78 нь “Тодорхой үр дүнд хүрсэн”, 49 нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, 17 нь “Үр дүнгүй” байна.

**9.8 их наяд
төгрөгийн
хөрөнгө оруулалт**

Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан ТАХ-нд нийт 9.8 их наяд төгрөг зарцуулсан ч улс хэрхэн хөгжиж, ямар эерэг өөрчлөлт бий болсныг тооцоогүй байна.

2.17. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч болон гүйцэтгэлийг үнэлж байгаа байгууллагууд төлөвлөсөн ТАХ-г хэдэн хувьтай хэрэгжүүлсэнд ач холбогдол өгч байгаагаас бус хэрэгжүүлснээр ямар үр дүн, үр нөлөө бий болсныг тооцож үнэлээгүй байна. Энэ нь холбогдох байгууллагууд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7-д заасан цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүйг харуулж байна.

2.18. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1-д “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх”-аар тусгасан ба Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр эдгээр баримт бичигт тусгасан зорилго, зорилт хэрхэн хэрэгжиж, зорилтот түвшинд хэр ойртож байгааг холбогдох байгууллагууд тооцож үнэлээгүй байна.

Монгол Улсын 2023 оны статистик үзүүлэлт

2.19. Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2023 оны танилцуулга”-д танилцуулсан статистик мэдээлэл өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөнийг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зарим зорилготой харьцуулан авч үзэхэд дараах байдалтай байна.

УХЖТ-ны зорилго	2022 оны статистик үзүүлэлт	2023 оны статистик үзүүлэлт	Тайлбар
Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	Цэцэрлэгийн тоо - 1413 Хүүхдийн тоо – 266024 Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт – 30 ЕБС-ийн тоо – 859 Сурагчийн тоо - 746405 ЕБС-ийн бүлэг дүүргэлт - 32	Цэцэрлэгийн тоо - 1410 Хүүхдийн тоо – 274236 Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт – 30 ЕБС-ийн тоо – 871 Сурагчийн тоо - 771722 ЕБС-ийн бүлэг дүүргэлт - 32	ЕБС, цэцэрлэгт суралцагчдын тоо өмнөх оноос нэмэгдсэн ч анги дүүргэлтийн хэмжээ өөрчлөгдөөгүй нь хүртээмж нэмэгдсэн байна. Энэ зорилгын үр дүн тодорхой хэмжээнд гарсан байна.
Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, өрийн менежментийг сайжруулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангана.	Нэгдсэн төсвийн орлого 18521.6 тэрбум төгрөг, Тэнцвэржүүлсэн тэнцэл -1032.7 тэрбум төгрөг, Инфляцын түвшин 13.2 хувь	Нэгдсэн төсвийн орлого 24310.1 тэрбум төгрөг, Тэнцвэржүүлсэн тэнцэл 763.4 тэрбум төгрөг, Инфляцын түвшин 7.9 хувь	Нэгдсэн төсвийн орлого 31.3 хувиар өссөн. Тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан. Инфляцын түвшин 5.3 хувиар буурсан байна. Энэ зорилгын үр дүн тодорхой хэмжээнд гарсан байна.
Аж үйлдвэржилтийн сэргэлтийг	Чулуун нүүрс 29672 м.тн,	Чулуун нүүрс 69586 м.тн,	Уул уурхай олборлох аж үйлдвэрийн үйлдвэрлэл өмнөх оноос өссөн

эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.	Хүрэн нүүрс 7536 м.тн, Баяжуулсан нүүрс 3405 м.тн, Газрын тос 2565 м.тн, Зэсийн баяжмал 1190 м.тн, Төмрийн хүдэр 7660 м.тн Нүүрсэн шахмал түлш 592.0 м.тн, Шохой 66496 тн, Катодын зэс 9736 тн, Цемент 1374.0 м.тн	Хүрэн нүүрс 11606 м.тн, Баяжуулсан нүүрс 6979 м.тн, Газрын тос 4889 м.тн, Зэсийн баяжмал 1395 м.тн, Төмрийн хүдэр 5332 м.тн Нүүрсэн шахмал түлш 414.0 м.тн, Шохой 58815 тн, Катодын зэс 9661 тн, Цемент 1714.0 м.тн	үзүүлэлттэй байгаа ч уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшин буурсан /цементээс бусад/ байна. Энэ зорилгын үр дүн гараагүй байна.
Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 35340, Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн 35220, Нас барсан 766 иргэн, Учирсан хохирол 347.9 тэрбум төгрөг, Авлигын хэрэг 475	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 35574, Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн 35292, Нас барсан 848 иргэн, Учирсан хохирол 449.2 тэрбум төгрөг, Авлигын хэрэг 569	Бүртгэгдсэн гэмт хэрэг 0.7 хувиар өссөн, учирсан хохирол 29.1 хувиар нэмэгдсэн, нас баралт 10.7 хувиар өссөн, авлигын хэрэг 19.8 хувиар өссөн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээний үр дүн буурсан байна. Нөгөө талаар энэ зорилгын хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь оновчтой бус байна.


2.20. Дээрх мэдээллээс харахад Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байгаа ТАХ-ний үр дүнд зарим зорилго тодорхойлсон үр дүндээ хүрээгүй байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

Улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт **23** хувьтай байна.

2.21. Өмнөх аудитаар холбогдох ТЕЗ-дад нийт 13 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг дүрслэлээр харуулав.

Дүрслэл 4: Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт



Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт **23** хувьтай байна.

Өмнөх аудитаар өгсөн зарим зөвлөмжид тусгасан алдаа, зөрчил энэ аудитаар дахин илэрч байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө **70.8** хувьтай хэрэгжсэн бөгөөд нийт төсөл, арга хэмжээний **28.4** хувь нь “Үр дүнтэй”, **38.8** хувь нь “Тодорхой үр дүнд хүрсэн”, **24.4** хувь нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, **8.5** хувь нь “Үр дүнгүй” байна.
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасан төсөл, арга хэмжээнд тавих шаардлага ялгаатай байгаа нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө тухайн жилийн төсвийн тухай хуультай уялдахгүй байхад ихээхэн нөлөөлж байна.
3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжилтийн хэмжээг бодитой тодорхойлоогүйгээс төлөвлөсөн төсөл, арга хэмжээ зорилтот түвшинд хүрэхгүй, улмаар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг бууруулж байна.
4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс санал авах, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх асуудал хангалтгүй, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан арга хэмжээг тусгахад чиглэсэн бодлого баримталж байгаа нь "Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим"-ыг алдагдуулж байна.
5. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч байгууллагууд, Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар бодит гүйцэтгэл, холбогдох нотлох баримтад үндэслэж бодитой үнэлээгүй, Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хэрэгжүүлэгч байгууллагуудын дундаж үнэлгээг гаргахдаа алдаа гаргасан, мөн уг хоёр байгууллагын тайлан, үнэлгээ адил байгаа зэрэг нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг ач холбогдол өгч үнэлдэггүйг харуулж байна.
6. Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагууд төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэдэн хувьтай хэрэгжүүлсэнд ач холбогдол өгч байгаагаас төсөл, арга хэмжээний үр дүнд жилийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичгийг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө бий болж байгааг тооцож үнэлээгүй нь хууль, эрх зүйн зохицуулалт дутагдалтай, уг үнэлгээг хийх тогтолцоо бүрдээгүйтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл нийт **9.8** их наяд төгрөг зарцуулснаар нийгэмд ямар эерэг өөрчлөлт бий болсон нь тодорхойлогдохгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Улсын Их Хуралд толилуулах нь:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т "... Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн ..., Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан батлах" гэж заасан бүрэн эрхийн дагуу тухайн жилийн төсвийн тухай хуулийг батлахдаа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулахад анхаарал хандуулахыг толилуулж байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлснээр бий болох үр дүнт тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг төлөвлөн, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжилтийн хэмжээг тооцоо, судалгаанд үндэслэн бодитой, хэмжигдэхүйц тодорхойлох,
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.7-д "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад оролцох төрийн байгууллага болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг хангаж, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэний оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх" гэж заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд холбогдох талуудын саналыг авч "Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим"-ыг ханган ажиллах,

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарт:

1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан арга зүйн дагуу Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд бодит гүйцэтгэл, нотлох баримтад суурилсан, цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоо бий болгох,
2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө, эерэг өөрчлөлт бий болсныг үнэлж тооцон Үндэсний статистикийн хорооноос гаргадаг статистикийн өгөгдөлд оруулж, нийтэд ил тод, ойлгомжтой хэлбэрээр байршуулах ажлыг зохион байгуулах.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд нарт:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасан төсөл, арга хэмжээнд тавих шаардлагын ялгаатай байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах, шийдвэр гаргах этгээдэд уламжлах.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал болгож буй төсөл, арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжилтийн хэмжээг тооцоо, судалгаанд үндэслэн бодитой, хэмжигдэхүйц тодорхойлон, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс санал авч нэгтгэх,
2. Хариуцан хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан арга зүйн дагуу бодит гүйцэтгэл, нотлох баримтад суурилсан, цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ирүүлсэн санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.03.14 № ХТ/487
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

"Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна.

Тайлангийн дүгнэлтэд "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллагууд төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэдэн хувьтай хэрэгжүүлсэнд ач холбогдол өгч байгаагаас төсөл, арга хэмжээний үр дүнд нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө бий болж байгааг тооцож, үнэлэхгүй байна." гэж, "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасан төсөл, арга хэмжээнд тавих шаардлага ялгаатай байгаа нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө тухайн жилийн Төсвийн тухай хуультай уялдахгүй байхад ихээхэн нөлөөлж байна." гэж тус тус тусгасанд дараах тайлбарыг хүргүүлж байна.

1.Монгол Улсын макро эдийн засаг 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 7.0 хувиар өсөж, гадаад валютын албан нөөц 2023 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 4.9 тэрбум ам.долларт хүрч, инфляц 7.9 хувь хүртэл буурч, нэг оронтой тоонд орсон. Макро эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, экспортын орлогын 86 хувь, эдийн засгийн өсөлтийн 3.4 нэгж хувийг уул уурхайн салбар бүрдүүлээд байна. Харин өрхийн нийт хэрэглээ өсөж байгаа хэдий ч, тус өсөлтийг бодит орлогын өсөлтийн хэмжээ гүйцэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газраас Улсын хөгжлийн богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг буюу Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлсэн нь дээрх нөхцөл байдалд нөлөөлсөн гэж үзэж байна. Гэхдээ улсын хөгжлийн төлөвлөгөөнд туссан төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг жилийн эцсийн байдлаар холбогдох журмын дагуу хувиар тооцон үнэлэх боломжтой бөгөөд нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг макро эдийн засгийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр төсөөлнө. Харин нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дараа онд бодит судалгаа, тооцоо, дүн шинжилгээнд үндэслэн албан ёсны статистик тоон мэдээлэл гарсны тооцох боломжтойг анхаарах нь зүйтэй.

2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3-т "Улсын төсөв нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх" гэж, 9.5.3-т "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах" гэж; Төсвийн тухай хуулийн 29¹.2.5-д "тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх" гэж; "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.1.1-д "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, хөгжлийн бодлого, зорилго болон зорилтыг хангах зорилгоор цахим системийн бодлогын дэд системд хөгжлийн бодлогын баримт бичгийг дараах байдлаар холбоно." гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн жилийн төлөвлөгөөний арга хэмжээг төсөвлөх үйл ажиллагаатай уялдуулах чиглэлээр олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Засгийн газраас Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авсан хэдий ч Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагч болон төсөл, хөтөлбөрийн үр дүнг сайжруулах үндсэн үйл ажиллагаа, түүнчлэн он дамжин үргэлжилж буй төсөл, арга хэмжээг төсвийн алдагдлын хязгаарт багтаан төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллахад мөн анхаарч ажилласан болно.

Иймд дээрх 2 заалтад хамааралтай асуудлыг бодит байдалтай уялдуулан дүгнэхэд анхаарч өгөхийг хүсье.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА



Б.ГАНБАТ

Эдийн засаг, хөгжлийн яамны ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАГДЖАВ ТАНАА

2024.03.14 № 03/509

танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Танай байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дүгээр зүйлийн 9.8.1, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/152 дугаар тушаалыг үндэслэн "Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлангийн төслийн аудитын шалгуур үзүүлэлт хэсэгт "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль" гэж заасныг "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай" гэж өөрчлөх;

2. Төслийн 1.10, 1.11, 1.14, 1.16, 1.18, 1.22, 1.27 дахь хэсэгт "Улсын хөгжлийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд ..." гэснийг "Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд ..." гэж өөрчлөх;

3. Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан "хөрөнгө оруулалт"-ын төслийн тухайд шаардлагатай санхүүжилтийг тусгасан. Харин арга хэмжээний хувьд байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт шаардахгүй тул тайлангийн төслийн 1.10, 1.11, 1.12, 1.13 дахь заалтаас "77 ТАХ-ний хөрөнгө оруулалтыг тооцоолоогүй" гэснийг хасах;

4. Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний хувьд зураг төсөв шаардагдахгүй 13 арга хэмжээ байсан тул тайлангийн төслийн 1.14-т туссан "Зураг төсөвгүй-13" гэснийг хасах;

5. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалаар төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дунджийг тооцдог. Яам, байгууллагын үнэлгээг гаргахдаа тухайн байгууллагаас үндсэн хэрэгжүүлсэн шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээг тооцох замаар төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээг тооцож, улмаар тухайн байгууллагын үнэлгээний дунджийг гаргадаг. Тухайлбал, Сангийн яамны үндсэн хэрэгжүүлэх 5 арга хэмжээ тусгагдсан ба тус 5 арга хэмжээ нь 16 шалгуур үзүүлэлттэй. Үүнээс 7 шалгуур үзүүлэлт нь Сангийн яамны хариуцан хэрэгжүүлсэн, 9

240738

шалгуур үзүүлэлт нь бусад байгууллагууд хариуцан хэрэгжүүлсэн тул Сангийн яамны дундаж үнэлгээг тооцохдоо 7 шалгуур үзүүлэлтийн дунджаас төсөл, арга хэмжээний дунджийг тооцож гаргасан. Харин Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас нийтлэг журамд заасан аргачлалаар бодлогын баримт бичгийн биелэлтэд дараагийн шатны үнэлгээг хийж гүйцэтгэсэн тул тус байгууллагаас санал авах нь зүйтэй.

6. Яам, байгууллага улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, нийтлэг журмын 10.7.2-т "бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн хагас жилийн болон жилийн эцсийн мэдээ, тайланг сайд, удирдлага, агентлагийн даргын хурлаар хэлэлцүүлсний дагуу цахим санд оруулан баталгаажуулж, жилийн эцсийн тайланг холбогдох байгууллагад албан бичгээр хүргүүлэх;" гэж заасны дагуу Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, цахим системээр баталгаажуулж, албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлдэг тул бодитой үнэлгээгүй гэж дүгнэх нь учир дутагдалтай. Дундаж үнэлгээг тооцохдоо батлагдсан 201 шалгуур үзүүлэлтээс тухайн байгууллагын үндсэн хэрэгжүүлсэн шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээг тооцох замаар төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээг тооцож, улмаар тухайн байгууллагын үнэлгээний дунджийг гаргадаг. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Эдийн засаг, хөгжлийн яамнаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулах чиг үүрэгтэй ажилладаг бөгөөд уг бодлогын баримт бичгийн биелэлтийг улсын хэмжээнд нэгтгэн, нийтлэг журамд заасан аргачлалын дагуу ач холбогдол өгч, үнэн зөв бодитой хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж ажилладаг. Иймд нэгдсэн дүгнэлтийн 5 дахь заалтыг хасуулах саналтай байна.

7. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2023 онд 7.0 хувьд хүрч хамгийн өндөр өсөлттэй 20 улсын нэг болсон, энэхүү өсөлтөд уул уурхайн салбар 23.4 хувь, тээврийн салбар 39.3 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 4.1 хувь, үйлчилгээний салбар 9.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Инфляц 2022 оны эцэст 13.2 хувь байсан бол 2023 оны эцэст 7.9 хувь болж нэг оронтой тоонд орсон. Гадаад валютын улсын албан нөөц 4 тэрбум 918 сая ам.доллар болж өссөн. Экспортын хэмжээ 15.2 тэрбум ам.доллар буюу түүхэн дээд хэмжээндээ хүрч дэлхийн 81 улсад бүтээгдэхүүнээ экспортолсон бол төгрөгийн ханш чангарч ам.долларын ханш 2024 оны 03 дугаар сарын 05-ны байдлаар 3,375.68 төгрөг болж буурсан нь 9.8 их наяд төгрөгийг зарцуулж, богино хугацааны хөгжлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд бий болсон үр нөлөө гэж үзэж байна. Иймд нэгдсэн дүгнэлтийн 6 дахь заалтыг нягталж, өөрчлөх саналтай байна.

8. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.5.1-т "улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах;", 9.5.3-т "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах." чиг үүрэг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгогдсон тул Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд санхүүжих дүнг бууруулж тусгасан төсөл, арга хэмжээний талаарх зөвлөмжийг тус байгууллагад өгөх нь зүйтэй.

9. Үндэсний статистикийн хорооноос Монгол Улсын нийгэм, эдийн засгийн 2023 оны урьдчилсан гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр танилцуулсан бөгөөд Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг нийтлэг журамд заасан хугацаанд буюу 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/105 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж тайлагнасан тул статистик тоон мэдээллийг харьцуулан авч үзэх боломжгүй байсан. Цаашид албан ёсоор танилцуулдаг статистик тоон мэдээлэлд үндэслэн хэрэгжүүлсэн зорилго өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөнийг яамд, байгууллагууд харьцуулж биелэлтийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА


 И.БАТХҮҮ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Санал 1	Саналыг харгалзан үзэж найруулгын өөрчлөлт хийсэн.
Санал 2	Саналыг харгалзан үзэж найруулгын өөрчлөлт хийсэн.

Эдийн засаг, хөгжлийн яамны ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Санал 1	Саналыг хүлээн авч өөрчилсөн.
Санал 2	Саналыг хүлээн авч өөрчилсөн.
Санал 3	Төлөвлөсөн ТАХ-г хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хэмжээг тусгасан байхаар Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9, 6.10.2-т тус тус заасан тул саналыг хүлээн авах боломжгүй.
Санал 4	Саналд тусгасан ТАХ тус бүрийг шалгаж, 1 нь зураг төсөв шаардахгүй тул хасав. Бусад нь зураг төсөв шаардлагатай ТАХ байгаа тул өөрчлөлт оруулж, хэвээр үлдээсэн болно.
Санал 5	Нотлох баримтаар дэмжигдэж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Санал 6	Нотлох баримтаар дэмжигдэж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Санал 7	Ирүүлсэн саналд тусгасан үзүүлэлтэд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний баримт бичигт тусгасан ТАХ-г хэрэгжүүлснээр бодлого тус бүрийн үр дүнд хэрхэн нөлөөлснийг тооцоолсон баримт байхгүй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Санал 8	Саналыг харгалзан үзэж өөрчлөлт хийсэн.
Санал 9	Тайлбар ирүүлсэн байгаа тул тайланд ямар нэг өөрчлөлт оруулаагүй болно.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд зөрүүтэй туссан ТАХ-ний жагсаалт

№	ТАХ-ний нэр	Шалгуур үзүүлэлт бүхий ТАХ-ний нэр
1	Багшийн ур чадварыг сайжруулж, үнэлэмжийг дээшлүүлэх “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар
2	Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, монгол хүний хандлага, хүмүүжил, төлөвшилд нийцсэн түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны агуулгаар баяжуулсан сургалтын хөтөлбөр боловсруулах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар
3	Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдах суралцагчийн хувь
4	Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний хэрэгжилт, хувиар
5		“Харшлаас сэргийлэх” арга хэмжээний хэрэгжилт, хувиар
6		“Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлж, Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах ажлын явц, хувиар
7	Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	Өвчний хяналт, зохицуулалтын төвийн барилгын ажлын явц, хувиар
8	Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж, нэгдсэн сан бүхий мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх	Мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх ажлын явц, хувиар
9		Телемедицин нэвтрэх эрүүл мэндийн байгууллагын тоо
10	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэх	Ариун цэврийн байгууламжийг шинэчлэх сумын эрүүл мэндийн төвийн тоо
11	Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, эрэлт, хэрэгцээтэй уялдуулан дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх	Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, эрэлт, хэрэгцээний чиглэлээр хийх судалгааны тоо
12		Ажил мэргэжлийн эрэлтэд суурилан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар
13	Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын барилгын ажлын явц, хувиар
14	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах цэвэр эрчим хүчний ногоон төслүүдийг хэрэгжүүлэх	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар
15	Геологийн зураглал, судалгааны ажлыг эрчимжүүлэн, гео мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, үйлчилгээг	Геологийн 1:25000-ны масштабын зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар
16		Геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг хийх талбайн хэмжээ, хувиар
17		Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгаа бүхий нутаг дэвсгэрийн хэмжээ, хувиар

18	цахимжуулах	Геологийн зураглалыг төрөлжүүлж, шинээр болон үргэлжлүүлэн хийх судалгааны ажлын тоо
19		Мэдээллийн баяжуулалт хийж, үйлчилгээг цахимжуулах гео мэдээллийн нэгдсэн сангийн тоо
20	Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх	Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар
21		“Цахим нэг цонхны үйлчилгээ”-ээр олгох гадаадын хөрөнгө оруулалтын үйлчилгээний тоо
22		Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /КИОСК/ суурилуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар
23		Цахим виз олгох улсын тоог нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар
24	Зарим төрлийн төрийн хяналт шалгалтыг зогсоож, зөвлөн туслах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар
25	Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төслийн хэрэгжилт, хувиар
26	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох тогтолцоог бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх	Камерын хяналтын төв байгуулах аймгийн тоо
27	Дулааны цахилгаан станц, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг дотоодын цэргийн хамгаалалтад авах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар
28	Хүн амын унд, ахуйн ус хангамжийн нөөц тогтоох хайгуул судалгаа хийх	Нөөц тогтоох сумын төвийн тоо
29	Хөвсгөл нуурт живсэн машин техникийг татаж гаргах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар
30	Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилгын хэрэгжилтийг хангах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар
31	Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг барих төслийн явц, хувиар
32	Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Аймгийн төв, суурин газрын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн явц, хувиар
33		Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох ажлын явц, хувиар

Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нь хасагдаж туссан төсөл, арга хэмжээ

сая төгрөг

№	ТАХ-ний нэр	Шалгуур үзүүлэлт бүхий ТАХ-ний нэр	Санхүүжилтийн хэмжээ	2023 оны Төсвийн тухай хуульд туссан тухайн жилд санхүүжих дүн	УХЖТ Төсвийн тухай хуульд туссан санхүүжилтийн зөрүү
1	Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Шинээр барих болон өргөтгөх спорт заалны тоо	17,216.6	9,804.0	7,412.6
2	Эрдэм шинжилгээний байгууллагуудын нэгдмэл байдлыг хангах, уялдаа холбоог сайжруулах	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын ажлын явц, хувиар	50,378.8	24,532.7	25,846.1
3	Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар	16,500.0	2,400.0	14,100.0
4	Олон улсын жишигт нийцсэн спорт цогцолборыг ашиглалтад оруулж, хүн амын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих	Ашиглалтад орох спортын ордон болон цогцолборын тоо	75,320.9	51,846.5	23,474.4
5	Хүүхдийн хөгжлийг дэмжих “Найрамдал-2” зуслангийн цогцолбор барих	Барилгын ажлын явц, хувиар	24,000.0	1,600.0	22,400.0
6	Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийн барилгын ажлын явц, хувиар	16,788.7	12,308.0	4,480.7
7		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх Хөдөлмөр эрхлэлтийн төвийн барилгын ажлын явц, хувиар	17,279.5	16,112.3	1,167.2
8	Боомтуудын зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх дэд бүтэц, барилга байгууламж барих	Хилийн боомтуудыг орчин үеийн технологи бүхий хяналт шалгалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувиар	63,595.9	27,879.6	35,716.3
9		Замын-Үүд эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн дэд бүтэц, барилгын ажлын явц, хувиар	12,523.4	472.6	12,050.8
10	Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх	Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар	33,844.3	19,461.3	14,383.0

11	Эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх	Төвлөрсөн хот, сум, суурин газарт эрчим хүчний эх үүсвэр шинээр барих, өргөтгөх үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	157,165.7	151,659.2	5,506.5
12	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах цэвэр эрчим хүчний ногоон төслүүдийг хэрэгжүүлэх	Ашиглалтад орох сэргээгдэх эрчим хүчний 10 МВт-ын станцын тоо	42,504.2	30,756.7	11,747.5
13	Цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэн алдагдлыг бууруулж, суурин газруудыг холбох	Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн 35 кВт-ын цахилгаан дамжуулах шугам барих ажлын явц, хувиар	7,317.1	3,193.8	4,123.3
14		Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн хэрэгжилт, хувиар	13,000.0	876.4	12,123.6
15	Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх	Шинээр 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв барих ажлын явц, хувиар	83,000.0	55,374.4	27,625.6
16		Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүрэгт хэрэгжих “Улаанбаатарын дулаан хангамж төсөл”-ийн хэрэгжилт, хувиар	22,811.5	13,596.0	9,215.5
17	Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулах	“Шинэ Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	13,430.0	5,988.4	7,441.6
18	Газар тариалангийн үр ашгийг нэмэгдүүлэх, үр тариа хадгалах элеватор байгуулах	Ашиглалтад оруулах үр тариа, хүнсний ногооны агуулах, зоорины тоо	3,700.0	2,111.4	1,588.6
19	Соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	Байгалийн түүхийн шинэ музейн барилгын ажлын явц, хувиар	36,097.6	25,547.5	10,550.1
20		Үндэсний номын сангийн барилга угсралтын ажлын явц, хувиар	7,400.0	5,949.0	1,451.0
21	“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I, II”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I”-ийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	29,000.0	13,507.5	15,492.5

22	Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	12,900.0	549.4	12,350.6
23	Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	Шинээр үүрэн холбооны дамжуулах сүлжээнд холбох суурин газрын тоо	6,253.8	2,100.5	4,153.3
24	Улсын хил хамгаалах салбарын байгууламжийн шинэтгэл хийж, техник технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Улсын хил хамгаалалтын зориулалтын инженер, техникийн байгууламжийг шинэчлэх ажлын явц, хувиар	6,886.2	6,498.3	387.9
25	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг бэхжүүлэх хүрээнд аврах ажиллагаа явуулах нөхцөлийг сайжруулах	Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хэрэгжилт, хувиар	19,000.0	8,796.4	10,203.6
26	Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	252,658.5	46,708.4	205,950.1
27		“Орлогд нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл” төслийн явц, хувиар	36,728.0	16,106.8	20,621.2
28		“Залуус-1” орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар	11,980.0	8,415.5	3,564.5
29	Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Улаанбаатар хотын ус хангамжийг урт хугацаанд тогтвортойгоор нэмэгдүүлэх төслийн явц, хувиар	369,000.0	295,484.0	73,516.0
30	Хот доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах	Гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар	41,098.7	26,471.0	14,627.7
31	Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	“Сумын хөгжил” арга хэмжээний хүрээнд инженерийн дэд бүтэц байгуулах сумын тоо	31,800.0	17,428.7	14,371.3
32		Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын барилгын ажлын явц, хувиар	85,500.0	77,706.8	7,793.2

33	Бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих авто зам барих төслүүдийг хэрэгжүүлэх	Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн 121 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар	30,220.0	20,169.9	10,050.1
34		Жаргалтхаан-Өмнөдэлгэр-Рашаан хад-Өглөгчийн хэрэм-Биндэр-Баян-Адарга-Дадал чиглэлийн 290 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар	50,910.0	11,067.6	39,842.4
35		Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн 63 км авто замын барилгын ажлын явц, хувиар	36,890.3	20,525.8	16,364.5
36		Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км авто замын барилгын ажлын явц, хувиар	23,546.0	13,090.4	10,455.6
37		Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай 122.4 км авто замын барилгын ажлын явц, хувиар	33,620.9	26,359.5	7,261.4
38		Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто замын барилгын ажлын явц, хувиар	9,375.3	8,515.6	859.7
39		Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх хатуу хучилттай 56.9 км авто замын барилгын ажлын явц, хувиар	34,339.0	21,772.1	12,566.9
40	Сум, суурин доторх авто зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тав тухтай амьдрах орчныг сайжруулах	Сум, суурин доторх авто зам шинээр барих, өргөтгөх ажлын явц, хувиар	165,161.7	33,244.5	131,917.2
41		Сум, суурин доторх гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар	52,787.4	33,729.5	19,057.9
Нийт			2,053,530.0	1,169,718.1	883,811.9

Төсвийн тухай хуульд санхүүжих дүн нь нэмэгдэж туссан төсөл, арга хэмжээ

сая төгрөг

№	ТАХ-ний нэр	Шалгуур үзүүлэлт бүхий ТАХ-ний нэр	Санхүүжилтийн хэмжээ	2023 оны Төсвийн тухай хуульд туссан тухайн жилд санхүүжих дүн	УХЖТ Төсвийн тухай хуульд туссан санхүүжилтийн зөрүү
1	Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах	Ашиглалтад орох сургуулийн тоо	279,713.80	357,001.8	(77,288.0)
2	Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Сургууль, цэцэрлэгийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажлын явц, хувиар	10,880.00	55,521.2	(44,641.2)
3		Ашиглалтад оруулах дотуур байрны тоо	34,136.20	50,609.5	(16,473.3)
4	Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	Шинээр барих болон өргөтгөх нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн тоо	113,624.50	147,671.1	(34,046.6)
5	Ахмад настан, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих төвийг байгуулах	Ашиглалтад орох хөгжлийн төвийн тоо	23,632.20	26,159.2	(2,527.0)
6	Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих	Ашиглалтад орох соёл урлагийн байгууламж, музей болон номын сангийн тоо	71,085.70	99,875.3	(28,789.6)
7	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах цэвэр эрчим хүчний ногоон төслүүдийг хэрэгжүүлэх	160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих ажлын явц, хувиар	45,000.00	87,708.8	(42,708.8)
8	Цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэн алдагдлыг бууруулж, суурин газруудыг холбох	Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах “Эрчим хүчний төсөл-2” төслийн хэрэгжилт, хувиар	22,694.30	51,945.7	(29,251.4)
9	Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх	Хан-Уул, Баянгол дүүрэгт хэрэгжих “Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл”-ийн хэрэгжилт, хувиар	31,000.00	37,429.0	(6,429.0)

10	Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг түүхий эдийг боловсруулах хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх	Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	200,000.00	356,486.0	(156,486.0)
11	Дотоодын мах, сүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, хүн амын хэрэгцээнд зориулан нөөц бүрдүүлэх	Ашиглалтад орох сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, фермийн тоо	6,119.40	7,385.6	(1,266.2)
12	Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих	Усалгаатай талбайн хэмжээ, мянган га	18,000.00	18,512.7	(512.7)
13			2,150.00	2,414.0	(264.0)
14	Соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	“Чингис хаан” хаад, язгууртны шинэ музейн тохижилтын ажлын явц, хувиар	10,107.00	11,570.2	(1,463.2)
15		Улсын драмын эрдмийн театрын барилгын хүчитгэлийн ажлын явц, хувиар	1,186.70	1,712.8	(526.1)
16		Үндэсний археологи, угсаатны зүйн музей, лабораторийн барилга угсралтын ажлын явц, хувиар	7,850.00	12,378.3	(4,528.3)
17	Улсын хил хамгаалах салбарын байгууламжийн шинэтгэл хийж, техник технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Төвлөрсөн эрчим хүчинд холбогдох хилийн салбарын тоо	1,750.00	2,383.0	(633.0)
18	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох тогтолцоог бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх	Хууль сахиулах байгууллагын шинэчлэх барилгын тоо	26,022.00	35,179.0	(9,157.0)
19	Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах	Цөлжилтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэх талбайн хэмжээ, га	1,290.00	1,854.8	(564.8)
20	Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх	“Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийн явц, хувиар	37,826.80	68,920.8	(31,094.0)
21		“Солонго-1”, “Солонго-2” орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар	10,000.00	78,753.2	(68,753.2)
22	Шинэ суурьшлын бүс, чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэн, зураг төслийг боловсруулах объектын тоо	16,172.50	59,967.4	(43,794.9)

23	Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төслийн явц, хувиар	15,300.00	50,916.3	(35,616.3)
24	Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Улаанбаатар хотын инженерийн шугам, үерийн ус зайлуулах шугам, цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлын явц, хувиар	3,106.50	17,134.1	(14,027.6)
25	Хот доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах	Хот доторх авто зам шинээр барих, өргөтгөх ажлын явц, хувиар	9,192.10	11,156.9	(1,964.8)
26	Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Инженерийн шугам, үерийн ус зайлуулах шугам, цэвэр бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлын явц, хувиар	130,772.60	193,268.0	(62,495.4)
27	Бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих авто зам барих төслүүдийг хэрэгжүүлэх	Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн 90.1 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар	15,000.00	18,249.7	(3,249.7)
28		Чингис-Норовлин-Дадал чиглэлийн 255 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар	31,376.30	59,132.7	(27,756.4)
29		Хялганат-Хангал чиглэлийн эхлэлийн хатуу хучилттай 10 км авто замын барилгын ажлын явц, хувиар	2,000.00	2,328.8	(328.8)
30	Сум, суурин доторх авто зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тав тухтай амьдрах орчныг сайжруулах	Аймгийн төвүүдэд байгуулах зорчигч тээврийн авто буудлын тоо	3,000.00	3,976.7	(976.7)
Нийт			1,179,988.6	1,927,602.8	(747,614.2)

ТЕЗ-даас хүргүүлсэн саналд санхүүжих дүн нь тусгагдсан ч
Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд санхүүжих дүнгүй туссан төсөл, арга хэмжээ

сая төгрөг

№	ТЕЗ	ТАХ-ний нэр	Шалгуур үзүүлэлт бүхий ТАХ-ний нэр	ТЕЗ-даас хүргүүлсэн саналд туссан дүн
1	ЭМЯ	Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	“Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний хэрэгжилт, хувиар	3,000.0
2			“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний хэрэгжилт, хувиар	500.0
3			“Харшлаас сэргийлэх” арга хэмжээний хэрэгжилт, хувиар	600.0
4			“Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлж, Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах ажлын явц, хувиар	17,000.0
5			“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний хэрэгжилт, хувиар	10,000.0
6			“Хавдрын эсрэг” арга хэмжээний хэрэгжилт, хувиар	700.0
7	ЭМЯ	Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж, нэгдсэн сан бүхий мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх	Телемедицин нэвтрэх эрүүл мэндийн байгууллагын тоо	500.0
8	СоЯ	Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих	“Соёлын бүтээлч үйлдвэрлэл-I” арга хэмжээний хэрэгжилт, хувиар	4,500.0
9	БОАЖЯ	“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I, II”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл II”-ийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	48,496.7
10	БОАЖЯ	Цар тахлын дараах аялал жуулчлалын салбарыг сэргээж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, сурталчилгааг илэрвүүлэх	Аялал жуулчлалын салбарыг дэмжиж, жуулчдыг татах чиглэлээр хэрэгжүүлэх төслийн хэрэгжилт, жуулчдын тоо	38,920.0
11	БОАЖЯ		“FeelMongolia” аялал жуулчлалын цахим сурталчилгааны хэрэгжилт, хандалтын өсөлтийн хувиар	
12	БОАЖЯ	Ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн хомстол, доройтлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулах талбайн хэмжээ, мянган га	28,328.5
13	БОАЖЯ		Ойн хөнөөлт шавж, өвчний голомттой тэмцэх талбайн хэмжээ, мянган га	
14	БОАЖЯ		Ой зохион байгуулалт хийх талбайн хэмжээ, мянган га	
15	БОАЖЯ		Ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мянган га	
16	БОАЖЯ	Хөвсгөл нуурт живсэн машин техникийг татаж гаргах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	1,300.0
17	БОАЖЯ	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	Агаар дахь PM 2.5, PM10 тоосонцрын агууламжийн хэмжээ, мкг/м3	70,883.9
18	БШУЯ	Багшийн ур чадварыг сайжруулж, үнэлэмжийг дээшлүүлэх “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	5,405.5
19	БШУЯ	Суралцагчийн сургалтын ахиц дэвшлийн үнэлгээг хийж, ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулах	Бага, дунд боловсролын чанарын дундаж үнэлгээ, хувиар	5,000.0
20	БШУЯ		Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын үнэлгээ /PISA/-нд тулгуурлан зөвлөмж боловсруулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	173,320.3

21	БШУЯ	Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, монгол хүний хандлага, хүмүүжил, төлөвшилд нийцсэн түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны агуулгаар баяжуулсан сургалтын хөтөлбөр боловсруулах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	2,675.3
22	БШУЯ	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах 3-5 настай хүүхдийн хамран сургалтын хувь	50.0
23	БШУЯ	сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх 5 настай хүүхдийн хувь	
24	БШУЯ	Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах	Ашиглалтад орох цэцэрлэгийн тоо	536,100.0
25	БШУЯ	Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах цэцэрлэг, сургууль, дотуур байрны тоо	138,835.0
26	БШУЯ	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, эрүүл ахуйн стандартыг дээшлүүлж, “Үдийн хоол” хөтөлбөрт дунд ангийн сурагчдыг нэмж хамруулах	“Үдийн хоол” хөтөлбөрт хамрагдах дунд ангийн сурагчийн тоо	377,313.0
27	БШУЯ	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч, багш мэргэжлээр суралцагчид сурлагын амжилттай нь уялдуулан тэтгэлэг олгох	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	1,800.0
28	БШУЯ	Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгааны ажлыг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэх	Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардал, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар	12,000.0
29	БШУЯ	патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэх	Инновацын тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийг дэмжих ажлын явц, хувиар	5,800.0
30	БШУЯ	Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, эрэлт, хэрэгцээтэй уялдуулан дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх	Ажил мэргэжлийн эрэлтэд суурилан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	1,300.0
31	ГХЯ	Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих	“Дэлхийн монголчууд II” цогц арга хэмжээний хэрэгжилт, хувиар	2,300.0
32	ГХЯ	Цар тахлын дараах аялал жуулчлалын салбарыг сэргээж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, сурталчилгааг идэвхжүүлэх	“Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний хэрэгжилт, хувиар	5,500.0
33	ХЗДХЯ	Боомтуудын зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх дэд бүтэц, барилга байгууламж барих	Хүний биеийн давхцахгүй өгөгдөлд тулгуурласан шинээр суурилуулах ухаалаг гарцын тоо	20,400.0
34	ХЗДХЯ		Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	3,000.0

35	ХЗДХЯ	Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх	“Цахим архив, албан хэрэг хөтлөлт” арга хэмжээний хэрэгжилт, хувиар	2,384.5
36	ХЗДХЯ		Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /КИОСК/ суурилуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	2,300.0
37	ХЗДХЯ	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох тогтолцоог бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх	Камерын хяналтын төв байгуулах аймгийн тоо	94,171.0
38	ХЗДХЯ, ГХЯ	Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх	Цахим виз олгох улсын тоог нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	140.0
		Нийт		1,614,523.7

о о о

Зураг төсөвгүй ТАХ-ний жагсаалт

№	ТЕЗ	ТАХ-ний нэр	Шалгуур үзүүлэлт бүхий ТАХ-ний нэр
1	БШУЯ	Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Ашиглалтад оруулах дотуур байрны тоо
2			Шинээр барих болон өргөтгөх спорт заалны тоо
3	БШУЯ	Эрдэм шинжилгээний байгууллагуудын нэгдмэл байдлыг хангах, уялдаа холбоог сайжруулах	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын ажлын явц, хувиар
4	ЭМЯ	Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	Геронтологийн төвийн барилгын ажлын явц, хувиар
5			Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ын барилгын ажлын явц, хувиар
6			Баянзүрх дүүрэг дэх 300 ортой эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар
7	ЭМЯ	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэх	Ариун цэврийн байгууламжийг шинэчлэх сумын эрүүл мэндийн төвийн тоо
8	БШУЯ	Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийн барилгын ажлын явц, хувиар
9	ЭЗХЯ	Боомтуудын зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх дэд бүтэц, барилга байгууламж барих	Замын-Үүд эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн дэд бүтэц, барилгын ажлын явц, хувиар
10	ЗТХЯ	Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх	Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар
11			Хөөт-Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар
12	БОАЖЯ	Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх	Онги, Хэрлэн усан цогцолбор барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар

Суурь үзүүлэлттэй ТАХ-нд суурь түвшнийг тусгаагүй ТАХ-ний жагсаалт

№	ТЕЗ	ТАХ-ний нэр	Шалгуур үзүүлэлт бүхий ТАХ-ний нэр
1	БШУЯ	Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Ашиглалтад оруулах дотуур байрны тоо
2			Хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдах суралцагчийн хувь
3			Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах цэцэрлэг, сургууль, дотуур байрны тоо
4	ЭМЯ	Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний хэрэгжилт, хувиар
5			“Хавдрын эсрэг” арга хэмжээний хэрэгжилт, хувиар
6	ЭМЯ	Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийг	Шинээр барих болон өргөтгөх нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн тоо
7	БТСУХ	Олон улсын жишигт нийцсэн спорт цогцолборыг ашиглалтад оруулж, хүн амын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих	Ашиглалтад орох спортын ордон болон цогцолборын тоо
8	ХНХЯ	Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого,	Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, эрэлт, хэрэгцээний чиглэлээр хийх судалгааны тоо
9	ХНХЯ	Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Орлого багатай иргэдэд чиглэсэн мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар
10			Залуучуудад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, хөдөлмөрт бэлтгэх, ажлын байранд дадлагажуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар
11			Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх Хөдөлмөр эрхлэлтийн төвийн барилгын ажлын явц, хувиар
12	БШУЯ		Насан туршдаа суралцах боломжийг дэмжих, бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг баталгаажуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар
13	ЭЗХЯ	Үндэсний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх, чадавхжуулах “Үндэсний ханган нийлүүлэлт” арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар
14	ГХЯ	Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих	“Дэлхийн монголчууд II” цогц арга хэмжээний хэрэгжилт, хувиар
15	СоЯ		Ашиглалтад орох соёл урлагийн байгууламж, музей болон номын сангийн тоо
16	СаЯ	Боомтуудын зорчигч болон ачаа нэвтрүүлэх	Хилийн боомтуудыг орчин үеийн технологи бүхий хяналт шалгалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувиар
17	ЭХЯ	Эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх	Дулааны II цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станц барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар

18	ЭХЯ	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зо	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар
19			Ашиглалтад орох сэргээгдэх эрчим хүчний 10 МВт-ын станцын тоо
20	ЭХЯ	Цахилгаан дамжуулах агаарын шугам сүлж	Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлын явц, хувиар
21	ГХЯ	Цар тахлын дараах аялал жуулчлалын салбарыг сэргээж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, сурталчилгааг идэвхжүүлэх	“Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний хэрэгжилт, хувиар
22	БОАЖЯ	Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх	“FeelMongolia” аялал жуулчлалын цахим сурталчилгааны хэрэгжилт, хандалтын өсөлтийн хувиар
23	СаЯ	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг с	Татварын тайлагналт, хураалтыг цахимжуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар
24	СаЯ, ХНХЯ, ТАЗ	Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар
25	АТГ	Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар
26	ЦХХХЯ	Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилгын хэрэгжилтийг хангах	Шинээр үүрэн холбооны дамжуулах сүлжээнд холбох суурин газрын тоо
27	БОАЖЯ	Бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих авто зам барих төслүүдийг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар
28	ЗТХЯ	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто замын барилгын ажлын явц, хувиар	